


АГУУЛГА

НЭГ. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА	2
1.1. Төслийн нэр.....	2
1.2. Төсөл хэрэгжүүлэгчийн нэр	2
1.3. Төсөл хэрэгжүүлэгчийн хаяг.....	2
1.4. Төслийн зорилго	2
1.5. Төслийн ач холбогдол.....	2
1.6. Төслийн байршил.....	2
1.7. Үйлдвэрийн хүчин чадал.....	3
1.8. Эмульсийн тэсрэх бодис, үйлдвэрийн технологи.....	3
1.9. Дэд бүтэц, инженер хангамж.....	5
1.9.1. Цахилгаан хангамж.....	5
1.9.2. Усан хангамж.....	5
ХОЁР. ТӨСЛИЙН ТАЛБАЙ ОРЧМЫН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ ЭДИЙН ЗАСГИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА.....	13
2.1. Физик газарзүй, ландшафт	13
2.2. Төсөл хэрэгжих талбайн өндөржилт, гадаргын налуу	13
2.3. Геоморфологи	15
2.4. Цаг уур, уур амьсгал.....	15
2.4.1. Агаарын температур	16
2.4.2. Хур тунадас.....	17
2.4.3. Салхины горим.....	18
2.5. Гадаргын болон газар доорхи ус.....	20
2.6. Хөрсөн бүрхэвч.....	20
2.6.1. Хөрсөн бүрхэвчийн эвдрэл, талхагдал	22
2.6.2. Хөрсний хүнд металлын өнөөгийн түвшин	22
2.7. Ургамлан нөмрөгийн төлөв байдал	23
2.8. Амьтны аймаг.....	23
2.9. Тусгай хамгаалалттай газар нутаг.....	24
ГУРАВ. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ	26
3.1. Төслийн байршил, шийдэлтэй холбоотой болзошгүй нөлөөлөлийн үнэлгээ	28
3.2. Төсөл хэрэгжих үйл ажиллагааны үе шаттай холбоотой болзошгүй нөлөөлөл.....	29
3.3. Төслийн гол сөрөг нөлөөллийн үнэлгээний нэгдсэн хүснэгт	30
ДӨРӨВ. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ	31
ТАВ. ОРЧНЫ ТОХИЖИЛТ, ЦЭЦЭРЛЭГЖҮҮЛЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ.....	35
ЗУРГАА. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	36
ДОЛОО. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ.....	38
НАЙМ. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР	43
ЕС. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ.....	44
АРАВ. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН БҮСИЙН ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ.....	45

НЭГ. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

- 1.1. Төслийн нэр:** “Эмульсийн тэсрэх бодисын үйлдвэр, агуулахын цогцолбор”
- 1.2. Төсөл хэрэгжүүлэгчийн нэр:** “Орика Монголиа” ХХК (Улсын бүртгэлийн дугаар: 9019003068, Регистрийн дугаар: 2866838)
- 1.3. Төсөл хэрэгжүүлэгчийн хаяг:** Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг 1-р хороо, Даунтаун (Downtown) оффис 5-р давхар 501 тоот Утас: 11 329043, 99055306
- 1.4. Төслийн зорилго:** Патенттай, аюул осол багатай технологи, тоног төхөөрөмж бүхий үйлдвэрийг Монгол Улсад нутагшуулах, уул уурхайн томоохон төслийг хэрэгжүүлж буй Оюу толгой ХХК-д хямд үнэ, өртөгтэй сайн чанарын эмульсийн тэсрэх бодис нийлүүлэх, Монгол Улсын хөгжилд бодит хувь нэмэр оруулах, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх зорилготой.
- 1.5. Төслийн ач холбогдол:** Монгол улсын стратегийн ач холбогдол бүхий Оюу Толгой уурхай, тэнд ажиллаж байгаа 15000 гаруй ажилтнууд, улмаар төсвийн чухал орлогыг бүрдүүлэгч зэсийн хүдрийн экспортыг тасалдуулахгүй байх ач холбогдолтой төсөл юм.
- 1.6. Төслийн талбайн байршил:** Эмульсийн тэсрэх бодисын үйлдвэр, агуулахын цогцолбор нь Өмнөговь аймгийн Ханбогд сумын нутаг дэвсгэр дэх Оюу Толгой уурхайн тусгай зөвшөөрлийн талбайд байрладаг.

Төслийн байршил



Газрын зөвшөөрөл: Өмнөговь аймгийн Ханбогд сумын засаг даргын 2011 оны 02 дугаар сарын 25-ны өдрийн 28 тоот шийдвэрийг үндэслэн 151100104 нэгж талбарын дугаартай 8489.092 га газрыг 5 жилийн хугацаатай уул уурхайн зориулалтаар авсан. Засаг даргын 2016 оны а/74 тоот шийдвэрээр 2036 оны 03 сарын 23-ний өдөр хүртэл 20 жилийн хугацаатай сунгасан болно.

1.7. Үйлдвэрийн хүчин чадал: Үйлдвэрлэлийн зориулалттай эмульсийн тэсрэх бодисын үйлдвэр нь жилд 50,000 тн тэсрэх бодис үйлдвэрлэх суурьлагдсан хүчин чадалтай бөгөөд Оюу толгойн ил, далд уурхайн чулуулгийн шинж чанар, тэсэлгээний параметр, тэсэлгээ хийх арга аргачлал зэргээс хамааран өөр өөр нэр төрлийн эцсийн бүтээгдэхүүн /тэсрэх бодис/ үйлдвэрлэн нийлүүлдэг.

Хүснэгт 2-1. Үйлдвэрийн хүчин чадал

№	Тодорхойлолт	Тэсрэх бодисын нэр	Ашиглалтын жил			
			2024 он	2025 он	2026 он	2027 он
1	Далд уурхайд	Эмульсийн ТБ/Субтек Велкро/, тн	2000	2000	2000	2000
2	хэрэглэх	Эмульсийн ТБ/Субтек Чаржэ/, тн	2000	2000	2000	2000
3	Ил уурхайд	Эмульсийн ТБ/Форгис Экстра/, тн	10000	10000	10000	10000
4	хэрэглэх	Эмульсийн ТБ/Форгис Эклипс/, тн	25000	25000	25000	25000
		Нийт, тн	39000	39000	39000	39000

1.8. Эмульсийн тэсрэх бодис, үйлдвэрлэлийн технологи

Уул уурхайн ашиглалт, олборлолтод тэсэлгээний ажил үйлчилгээ зайлшгүй шаардлагатай байдаг тул дотооддоо олон улсын чанар, стандарт бүрэн нийцсэн хямд үнэ өртөг бүхий сайн чанарын тэсрэх бодис үйлдвэрлэх шаардлага зүй ёсоор тулгарч байгаа ба үйлдвэрлэлийн аюул осол багатай технологийг нэвтрүүлэх нь чухал юм.

“Орика Монголиа” ХХК нь Оюу толгойн ил уурхай, далд уурхайн тэсрэх бодисын хэрэгцээг хангаж, уг төслийн үйл ажиллагааны нэгж зардлыг бууруулах, байгаль орчинд ээлтэй, аюул осолгүй үйлдвэрлэл явуулах зорилтыг хангахад нь бодит хувь нэмэр оруулан ажиллаж байна.

Эмульсийн тэсрэх бодисын үйлдвэр нь ил уурхайн зориулалттай болон гүний уурхайн зориулалттай тэсрэх бодис үйлдвэрлэх 2 шугамтай бөгөөд шугам тус бүрийн суурилагдсан хүчин чадал нь 70тн/хоног байна.

Уг эмульсийн тэсрэх бодисын үйлдвэр нь аюул ослын зэрэг багатай бөгөөд усан фаз болон тосон фазыг хийгээр үлээлгэн холих замаар эмульсийн тэсрэх бодис үйлдвэрлэдэг. Энэ нь уламжлалт өндөр хурдаар эргэлдэн их хэмжээний хуйлрал, үрэлт, даралт үүсгэн хольдог технологи бүхий үйлдвэрүүдтэй харьцуулахад аюул осолгүй гэдгээрээ чухал ач холбогдолтой юм.

1.8.1. Үйлдвэрлэлийн үйл ажиллагаа, дараалал

Эмульсийн тэсрэх бодис нь үндсэн 3-н хольцоос бүрдэх бөгөөд эдгээр нь исэлдүүлэгч уусмал буюу усан фаз, тосон фаз болон хийжүүлэгч уусмал юм. Эдгээрийг үйлдвэрт тус тусад нь бэлтгэх бөгөөд усан фаз болон тосон фазыг үйлдвэрийн орчинд тусгай зориулалт бүхий төхөөрөмжид хольж үл тэсрэх хольц буюу эмульсийн матрицыг бэлтгэнэ. Хийжүүлэгч уусмал бэлтгэх багц тоног төхөөрөмжүүдийг үйлдвэрийн байрны гадна талд байрлах тусгай зориулалтаар тоногдосон контейнерт суурилуулан үйлдвэрлэлийг явуулж байна.

Эмульсийн тэсрэх бодис үйлдвэрлэх, үйлдвэрлэлийн технологи нь дэлхийн практикт өргөн нэвтэрч буй аюул ослын зэрэг багатай технологи бөгөөд усан фаз, тосон фазыг хольж эмульсийн матриц бэлтгэх процесс нь даралтат агаарын тусламжтайгаар хийгдэнэ. Энэ нь уламжлалт өндөр хурдаар эргэлдэн их хэмжээний хуйлрал, үрэлт, даралт үүсгэн хольдог технологи бүхий үйлдвэрүүдтэй харьцуулахад аюул осолгүй гэдгээрээ чухал ач холбогдолтой юм.

Исэлдүүлэгч усан уусмал бэлтгэхэд үндсэн түүхий эдээр аммиакийн шүүг ашиглах бөгөөд агуулахаас сэрээт ачигчийн тусламжтайгаар зөөвөрлөн үйлдвэрийн байранд байрлах бункерт хийнэ. Исэлдүүлэгч усан уусмал бэлтгэх сав /танк/ -нд ус хийж 80-85⁰С хүртэл халаах бөгөөд Аммиакийн шүүг бага багаар нэмж усан уусмалыг бэлтгэх ба уусмалыг даралтат агаарын тусламжтайгаар хольж бэлтгэнэ.

Тосон фаз буюу эмульсжүүлэгчийг хийгээр ажилладаг насосын тусламжтайгаар эмульс бэлтгэх зориулалттай сав руу шилжүүлэх бөгөөд технологийн орц найрлагын дагуу өгөгдсөн усан фаз, тосон фаз холилдон үл тэсрэх эмульс үүсгэнэ.

Эмульсийн тэсрэх бодис нь үндсэн 3-н хольцоос бүрдэх бөгөөд эдгээр нь исэлдүүлэгч уусмал буюу Аммиакийн шүүний усан уусмал, тосон фаз /Эмульсжүүлэгч, дизель түлш/ болон хийжүүлэгч уусмалаас бүрдэнэ.

Үйлдвэрийн эцсийн бүтээгдэхүүн болох ил уурхайн олборлолтын үйл ажиллагаанд ашиглагдах тэсрэх бодисыг тусгай зориулалт бүхий цооног цэнэглэгч автомашинуудад ачих бөгөөд эдгээр автомат тохируулга бүхий зориулалтын автомашинд ачигдсан эмульс болон хийжүүлэгч уусмалыг тэсэлгээний цооногт тодорхой орц найрлагын дагуу холин шахах үед эмульсийн тэсрэх бодис бий болдог.

Далд уурхайн үйл ажиллагаанд ашиглах эмульсийн тэсрэх бодис /Субтек Велкро/- ын үл тэсрэх эмульс болон хийжүүлэгч уусмалыг тус тусд нь зориулалтын ИВС саванд хийх бөгөөд зориулалтын автомашинаар тээвэрлэн далд уурхайд хүргэх ба далд уурхайн цооног цэнэглэгч төхөөрөмжтэй холбож цэнэглэлтийн үйл ажиллагааг орц найрлагын дагуу хийж эцсийн бүтээгдэхүүн тэсрэх бодисыг цооногт шахна.

1.8.2. Үйлдвэрлэлийн технологи процесс

Эмульсийн тэсрэх бодисын марк нэр төрлөөс хамааран тэдгээрийн орц найрлага, химийн бодисын зарцуулалт харилцан адилгүй байх бөгөөд ил уурхайд эмульсийн тэсрэх бодис /Фортис Экстра, Фортис Эклипс/, далд уурхайд эмульсийн тэсрэх бодис /Субтек Велкро, Субтек Чаржэ/ ашиглана.

Исэлдүүлэгч уусмал бэлтгэх: Эмульсийн тэсрэх бодисын үндсэн бүрэлдэхүүн болох исэлдүүлэгч усан уусмалыг бэлтгэхэд Аммиакийн шүү, Ус, Кальцжуулсан сода, Цууны хүчил, Тиомочевин, Мочевин зэргийг ашиглана.

Тосон фаз бэлтгэх: Тэсрэх бодис нэр төрлөөс хамааран тосон фазыг найрлага өөр өөр байх ба дизель түлш, ашигласан хөдөлгүүрийн тос, SMO, Параффин тос, эмульжүүлэгч /SB120I, E2170T, FBHP90, FBU513/ ашиглагдана. Тосон фазыг эмульсийн матрицын үйлдвэрлэлд оруулах ажиллагаа нь насосын тусламжтайгаар автомат болон гар горимд операторын хяналтын дор хийгдэнэ.

Эмульсийн матриц бэлтгэх: Исэлдүүлэгч усан уусмал болон тосон фазыг технологийн орц найрлагын дагуу хольж найруулсан бүтээгдэхүүнийг эмульсийн матриц гэнэ.

Эмульсийн матрицын хорт нөхцөл нь түүнийг бүрдүүлж буй түүхий эд химийн бодисуудын хортой нөхцөлөөр тодорхойлогдоно.

Эмульсжүүлэх төхөөрөмжийн технологи үйл ажиллагаа, процесс нь автомат хяналт, операторын шууд удирдлага дор хийгдэнэ. Эмульсийн матрицын зурамтгай шинж чанар, нягтын үзүүлэлт зэрэг чанарын хяналтыг тогтмол хийнэ.

Эмульс бэлтгэх төхөөрөмжид орц найрлага, технологийн процессын дагуу бэлтгэсэн эмульсийн матрицыг зориулалтын нөөцийн сав руу шилжүүлнэ. Нөөцийн савнаас бэлэн бүтээгдэхүүн эмульсийн матриц шилжүүлэх насосын тусламжтайгаар бүтээгдэхүүн зөөх ИВС чингэлэгт ачна.

Хийжүүлэгч уусмал: Хийжүүлэгч уусмалыг бэлтгэхэд ус, өнгө оруулагч бодис, натрийн нитрат, магнийн нитрат, кальцийн нитрат зэргийг ашиглах ба хийжүүлэгч нь эмульсийн матрицыг мэдрэгжүүлэх үүрэгтэй.

- Хийжүүлэгч уусмалын Температур (Үзүүлэлт 20- 30°C)
- Хийжүүлэгчийн Нягт (Үзүүлэлт 1.23-1.25g/cc)

Натрийн нитриттэй ажиллаж буй хүмүүс агаар салхины нөлөөгөөр амьсгалын замаар хордохоос хамгаалсан амны хаалт зүүх хэрэгтэй. Хийжүүлэгч нь эмульсийн тэсрэх бодисын найрлагыг бүрдүүлэх ба хоосон орон зайг бий болгоход ашигладаг. Хийжүүлэгч нь галын аюулгүй.

Хийжүүлэгч уусмал бэлтгэх сав руу хатуу нэмэгдэл хийсний дараагаар 30-60°C хэмтэй усыг тодорхой төвшинд хүртэл хийнэ. Хийжүүлэгч уусмалыг бүрэн уусгаж дууссаны дараа чанарын хяналт /гадаад төрх болон нягтралд/-ыг хийдэг. Хийжүүлэгч нэмэгдэл нь биеийн ил хэсэгт хүрэхэд загтнах, цэврүүтэх шинж тэмдэг илэрдэг. Амьсгалын замаар хордоход толгой эргэх, бөөлжих, толгой хэсгийн судасны өргөсөлт явагддаг байна.


1.9. Дэд бүтэц, инженер хангамж

1.9.1. Цахилгаан хангамж

Цахилгаан эрчим хүчний үүсгүүр

Тэсрэх бодисын үйлдвэрийн цахилгааны хэрэглээг Оюу толгой уурхайн өндөр хүчдэлийн цахилгаан дамжуулах шугамаас хангаж байна. Тэсрэх бодисын үйлдвэрийн цахилгааны хэрэглээ харьцангуй бага бөгөөд үйлдвэрийн дотоод бүтээгдэхүүн тээвэрлэлт, үйлдвэрлэлийн процесс нь даралтат агаарын тусламжтайгаар хийгдэж байна.

Зураг 1-1. Үйлдвэрлэлийн цахилгаан хэрэглээ



1.9.2. Ус хангамж

Үйлдвэрийн технологид шаардлагатай усыг зөврөөр хангах бөгөөд үйлдвэрийн байран дотор байрлах 25тн-ын багтаамжтай технологийн усан санд усыг нөөцлөн үйлдвэрлэлд ашиглана. Үйлдвэрлэлийн технологи болон ахуйн хэрэгцээнд шаардлагатай усыг Оюу толгой ХХК хариуцан үнэ төлбөргүй хангаж байна. Үйлдвэрийн технологид шаардлагатай усыг зөврөөр хангах бөгөөд үйлдвэрийн байранд 22000 литрийн эзлэхүүнтэй 1 ширхэг нөөцийн савыг байрлуулан усыг нөөцлөн технологид ашиглана.

Хүснэгт 1-1. Үйлдвэрлэлийн усны хэрэглээ

Тодорхойлолт	2024	2025	2026	2027	Нийт
Үйлдвэрийн технологийн усны хэрэгцээ, м ³	2722.84	3025.38	3025.38	3025.38	11798.975
Үйлдвэрийн халаалт, усны алдагдал, м ³	81	90	90	90	351
Лаборатори болон бусад усны хэрэглээ, м ³	16.11	17.9	17.9	17.9	69.81
Үйлдвэрийн цэвэрлэгээ, шүршүүр, м ³	64.44	71.6	71.6	71.6	279.24
Нийт	2884.39	3204.88	3204.88	3204.88	12499.025

Ахуйн хэрэгцээний усыг тооцох шаардлагагүй бөгөөд үйлдвэрийн ажилчид нь Оюу толгой уурхайн гэрээт компаниудын байрлаж буй хотхонд байрлан уурхайн гал тогоо болон бусад үйлчилгээний объектуудыг дотоод журамд тусгагдсан эрх үүргийн дагуу үйлчлүүлнэ.

1.9.3. Дулаан хангамж

Уг үйлдвэрийн дулаан хангамжийг ENH75S-720 маркийн цахилгаан халаагуураар хангах бөгөөд уг цахилгаан халаагуурын ажлын багтаамж нь 480литр ба усыг 192⁰С хүртэл халаах хүчин чадалтай юм. Энэхүү халаагуур нь 100⁰С-ийн температурт хамгийн ихдээ 140тн/цаг усыг халаах чадалтай төхөөрөмж юм.

Хүснэгт 1-2. Агаар халаах төхөөрөмжийн үзүүлэлт


ХТDQ-FD-10	Үзүүлэлт
Чадал	720 кВт
Ажлын багтаамж	480литр
Савны хэмжээ	750*1200
Хүчдэл	380 В

Жин	860 кг	
Овор хэмжээ	1900*1880*1700 мм	
Урсгал	140тн/цаг	

1.9.4. Барилга байгууламж

Эмульсийн тэсрэх бодисын үйлдвэр нь Оюу толгой ХХК-ийн MV-006709 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий талбайн зүүн хойд хэсэгт байрлаж байна.

Зураг 1-2. Үйлдвэрлэлийн талбайн харагдах байдал



Одоогоор тухайн талбай дээрх бүхий л объектуудыг “Орика Монголиа” ХХК хариуцан ажиллаж байна.

- Эмульсийн тэсрэх бодисын үйлдвэр
- Цэнэглэгч машины авто граж
- Түүхий эд аммиакийн шүүний агуулах-1200тн
- Дизель түлшний нөөцийн сав
- Хийжүүлэгч нэмэгдэл бэлтгэх байр
- Химийн бодис хадгалах агуулах
- Компрессорын байр
- Хооллох байр, Оффис
- Сэлбэг хэрэгслийн агуулах
- Бараа материалын агуулах
- Харуул хамгаалалтын байр
- Авто зогсоол

Эмульсийн тэсрэх бодисын үйлдвэр

Эмульсийн тэсрэх бодисын үйлдвэрийн барилга байгууламжийг 2011 онд “Оюу толгой” ХХК барьж байгуулан ашиглалтад оруулсан бөгөөд уг үйлдвэрийн байр нь 35*28 метрийн хэмжээтэй сандвичен барилга юм. Үйлдвэр нь өдөрт 70тн эмульсийн тэсрэх бодис үйлдвэрлэх хүчин чадал бүхий 2 шугамтай бөгөөд энэ нь Оюу толгой төслийн ил уурхайн олборлолт болон гүний уурхайн бүтээн байгуулалт, олборлолтын үеийн хэрэгцээг бүрэн хангахуйц хүчин чадалтай юм.

Зураг 1-3. Үйлдвэрийн ерөнхий төлөвлөлт, харагдах байдал



Авто машины граж

Тэсрэх бодисоор цооног цэнэглэгч машинуудын граж нь эмульсийн тэсрэх бодисын үйлдвэрийн барилгатай хамт нэг дор байрлах бөгөөд үйлдвэрийн байрнаас ханаар тусгаарлагдсан байх ба 13х20м хэмжээ бүхий ажлын талбайтай байна.

Уг барилгын өндөр нь 8.6м бөгөөд нэг дор 4 машин багтаах боломжтой зохион байгуулалтай ба тус бүрдээ гадагш гарах гарцтай байхаар шийдсэн. Мөн барилгын нэг хэсэгт сэлбэг хэрэгслийн агуулахыг тавцан зассан байна.

Зураг 1-4. Автогражийн зохион байгуулалт харагдах байдал



Эмульсийн тэсрэх бодисын үйлдвэрлэлд ашиглагдах химийн бодис, түүхий эдийн агуулах

Тэсрэх бодис үйлдвэрлэлд ашиглагдах химийн бодис/Аммиакийн шүү/-ын агуулах нь мөн адил сэндвичен байгууламж байх бөгөөд барилгын талбай нь 42*30 метрийн харьцаатай 2 тусдаа буюу голоороо үл шатах ханаар тусгаарлагдсан объект юм.

Аммиакийн шүү нь өөрөө шатамхай шинж чанартай учир агуулахын ханыг үл шатах сэндвичен материалаар барьж байгуулсан бөгөөд агуулахад агаарын урсгал чөлөөтэй нэвтэрч байхаар тооцож барьсан.

Мөн агуулахын шалыг бетондох аммиакийн шүү нь чийг шингээдэг шинж чанартай тул агуулахын шалыг шал бороо, цасны ус үл тогтох бага хэмжээний налуу гадаргуу үүсгэн цутгасан. Агуулахад борооны ус үл нэвчих байдлаар барьж байгуулах шаардлагын дагуу

агуулахын салхивчийг агуулахын дээврээр халхалж агуулахын их биеээс тодорхой зайд илүү гаргаж гүйцэтгэсэн.

Зураг 1-5. Агуулахын харагдах байдал



Зураг 1-6. Агуулахын дотор зохион байгуулалт



Гал унтраах усан сангийн байгууламж

Үйлдвэрлэл явуулж буй талбайн дэргэд буюу харуул хамгаалалтын байрны хажууд 16*26метрийн харьцаа бүхий сэндвичен байгууламж байна. Уг байгууламж нь гал эсэргүүцэх нөөцийн усан сан болон дагалдах шугам хоолойгоор бүрэн тоноглогдсон бөгөөд аливаа гэнэтийн осол аваар, гал гарсан тохиолдолд ашиглагдах цогц байгууламж юм.

Энэ байгууламжийг зөвхөн гал гарсан үед ашиглах бөгөөд Таван Орд ХХК хариуцан ажилладаг. Бидний зүгээс зөвхөн гал түймэр гарсан үед мэдэгдэх шаардлагатай бусад тохиолдолд үйлдвэрийн үйл ажиллагаанд хамааралгүй болно.

Зураг 1-7. Гал эсэргүүцэх 500 м³ багтаамжтай усан сан



Зураг 1- 8. Үйлдвэрлэлийн талбайн болон барилга доторх гал эсэргүүцэх шугам хоолой



Бараа материалын агуулах

Үйлдвэрлэлийн талбайн баруун урд хэсэгт сэлбэг хэрэгсэл, бараа материалын агуулахуудын зориулалтаар ашиглах 20 болон 40тн-ын контейнерүүдийг суурилуулсан бөгөөд бараа материалын төрөл, хадгалалтын норм стандартын дагуу тус бүрд нь хадгалах юм. Сэлбэг хэрэгсэл, бараа материалын агуулахын зориулалтаар 7 ширхэг 40тн-ын контейнер, 3 ширхэг 20тн-ын контейнер ашиглаж байна.

Дизель түлш хадгалах

Эмульсийн тэсрэх бодисын үйлдвэрлэл, тосон фаз бэлтгэхэд дизель түлш, хаягдал тос, эмульсжүүлэгч хэрэглэгдэх бөгөөд үйлдвэрлэлд шаардлагатай дизель түлш болон хаягдал тосыг Оюу толгой ХХК бүрэн хариуцах ба үйлдвэрлэлийн талбайн баруун хойд буланд дизель түлш хадгалах агуулахыг байгуулсан. Агуулахаас тосон фаз бэлтгэхэд шаардлагатай дизель түлшийг насосын тусламжтайгаар үйлдвэрийн байр руу шахаж өгөх ба шахагдан ирсэн дизель түлш нь тасалгаан дахь саванд эмульсжүүлэгчтэй холилдож, тосон фазыг үүсгэнэ.

Зураг 1-9. Түлшний агуулах



Тосон фаз бэлтгэх багц тоног төхөөрөмжүүд үйлдвэрийн хойд талд 20 тн-ын контейнерт суурилагдсан байна.

Хийжүүлэгч нэмэгдэл бэлтгэх байр

Тэсрэх бодисын чухал бүрэлдэхүүн хэсгийн нэг болох хийжүүлэгч уусмалыг үйлдвэрийн ард байрлуулсан 20 тн-ын контейнерт суурилуулсан багц тоног төхөөрөмжүүдэд тулгуурлан бэлтгэж байна.

Зураг 1-10. Хийжүүлэгч нэмэгдэл бэлтгэх байрны гадна болон дотор байдал



Агааржуулагч компрессорын байр

Зураг 1-11. Технологийн ус халаах байр, халаагч



Шалган нэвтрүүлэх пост

Уг барилга нь гаднаас үйлдвэрийн бүсэд нэвтэрч байгаа ажиллагсад болон бусад хүмүүсийн бичиг баримтыг шалгах зориулалтаар ашиглагдах байр байна. Тэсэрч дэлбэрэх аюултай бодис үйлдвэрлэдэг, хадгалдаг объект учир байнгын харуул хамгаалалтай байх нь гаднын халдлага болон аливаа эрсдэл зэргээс урьдчилан сэргийлэх боломжийг бий болгоно.

Зураг 1-12. Үйлдвэрийн шалган нэвтрүүлэх байрны зураг




ХОЁР. ТӨСЛИЙН ТАЛБАЙ ОРЧМЫН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ ЭДИЙН ЗАСГИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

2.1. Физик газарзүй, ландшафт

“Эмульсийн тэсрэх бодисын үйлдвэр, агуулах байрлах орчин нь физик газарзүйн мужлалтаар Говийн их мужийн Дорнод говийн муж, Дорнод говийн хотгорийн тойрогт (МУ-ын Үндэсний атлас, 2009), байгаль-нутаг дэвсгэрийн цогцолбор нөхцлийн мужлалаар Дорнод говийн цөлөрхөг мужийн Дорнод говийн өмнөд хэсгийн тойрогт хамаарна.


Зураг 2-1. Төслийн талбайн хамаарах физик газарзүйн муж



2.2. Төсөл хэрэгжих талбайн өндөржилт, гадаргын налуу


“Орика Монголиа” ХХК-ийн төслийн талбай нь нам бэсрэг уул, аараг толгод, ухаа гүвээт тал, тэгшивтэр хотос, талын байдалтай бөгөөд энэ орчимд хэвгийдүү тал гадарга зонхилно. Гадаргын хэвгийн зургийг (google earth) өндрийн тоон мэдээг ашиглан боловсруулалт хийсэн.

Зураг 2-1. Төслийн гадаргын налуужилтын зураг




“Орика Монголиа” ХХК-ийн төслийн талбай нь ойр орчим нь 1135.0-1241.0 м өндөржилттэй байна.

Зураг 2-2. Төслийн талбайн өндөржилтийн зураг




Зураг 2-3. Төслийн талбайн байрзүйн зураг



2.3. Геоморфологи

Эмульсийн тэсрэх бодисын үйлдвэр, агуулахын цогцолбор байрлах талбай нь Монгол орны геоморфологийн мужлалаар Дундговь-Өмнөговийн их мужийн Даланзадгад-Сайншандын дэд мужид хамрагдана. Энэ мужид тэгширсэн гадарга, нам уулс хоорондын тэгш тал, голын хөндий дахь хурмал хурдаст хотос гадарга, хөндийн ёроолын татам, нам дэнжийн гадарга зонхилдог.

Зураг 2-5. Геоморфологийн зураг



2.4. Цаг уур, уур амьсгал

Монгол орны уур амьсгалын мужлалаар гандуу дулаан зунтай бүсийн (V), хүйтэн өвөлтэй мужид байрладаг. Энэ ч утгаараа бусад бүс нутгуудтай харьцуулахад хур тунадас бага, хуурайшилт ихтэй, салхины хурд өндөр байдаг буюу тоосжилт үүсэх байгалийн суурь нөхцөлтэй. Уг төслийн талбай орчимд хавар, намартаа сэрүүн, зундаа халуун, өвөлдөө хүйтэн, эх газрын эрс тэс уур амьсгалтай.

2.4.1. Агаарын температур


Жилийн хамгийн хүйтэн сар нь 1 дүгээр сар бөгөөд агаарын дундаж температур -10.3°C хүйтэрдэг байна. 1 дүгээр сарын хамгийн их температур 7.8°C , хамгийн бага температур -29.7°C , хамгийн дулаан сар нь 7 дугаар сар бөгөөд агаарын дундаж температур $+25.5^{\circ}\text{C}$, хамгийн их температур $+40.5^{\circ}\text{C}$, хамгийн бага температур -0.4°C байдаг.

Хүснэгт 4-1. Агаарын температурын үзүүлэлт

Сар	I	II	III	IV	V	VI	VII	VIII	IX	X	XI	XII
Агаарын хамгийн их температур/ $^{\circ}\text{C}$ /	7.8	15.8	22.6	32.8	36.1	38.7	40.4	38.4	34.1	31.1	21.2	11.6
Агаарын хамгийн бага температур/ $^{\circ}\text{C}$ /	-29.7	-25.2	-14.7	-9.6	-3.2	5.8	-0.4	8.9	0.6	-8.6	-24.9	-28
Агаарын дундаж температур/ $^{\circ}\text{C}$ /	-10.3	-6.5	3.4	10.6	17.3	23.9	25.6	22.9	18.4	8.1	-1.0	-9.7


Жилийн, дулаан ба хүйтэн улирлын дундаж температурын олон жилийн явц болон түүний өөрчлөлтийн хандлагын байдлыг доор зурагт үзүүлэв.

Зураг 4-1. Сарын дундаж агаарын температурын явц



Агаарын үнэмлэхүй хамгийн их температур $+40.4^{\circ}\text{C}$ хүрч дулаарсан бол үнэмлэхүй хамгийн бага температур -29.7°C хүрч хүйтэрсэн байна.

Зураг 4-2. Жилийн дундаж агаарын температурын явц



2.4.2. Хур тунадас

Өвөлд орох цасны дундаж хэмжээ 10 см-ээс бага, цас тогтох хугацаа 11-р сарын 21-ээс 12 сарын 01, цас арилах хугацаа 3-р сарын 15 хүртэл үргэлжилдэг. Уур амьсгалын дулааралт, хуурайшилтын үйл явц сүүлийн жилүүдэд мэдэгдэхүйц илэрч байна. 2017-2023 онуудад тус аймагт 74.0-201.7 мм тунадас унасан байна. Жилд орох хур тунадасны дийлэнхи хувь нь зуны улиралд буюу 7, 8-р саруудад ордог байна.

Хүснэгт 4-2. Хур тунадасны үзүүлэлт /сараар/


I	II	III	IV	V	VI	VII	VIII	IX	X	XI	XII
Сарын нийлбэр, мм											
6.80	34.00	15.40	16.40	38.70	60.30	336.0	217.2	60.9	32.6	6.2	3.7

Нийлбэр тунадасны хэмжээнд гарч буй өөрчлөлтийг тодорхойлохын тулд жилийн болон дулаан, хүйтэн улирлын тунадасны олон жилийн явцыг гаргаж өөрчлөлтийг нь авч үзлээ. Жилийн нийлбэр хур тунадас 5-н жилийн хугацаанд дундаж 3.7-217.2 мм унасан байна. Хамгийн их нь 2021 онд унасан бол хамгийн бага нь 2017, 2023 онуудад унасан байна.

Хүснэгт 4-3. Хур тунадасны үзүүлэлт /жилээр/


2017	2018	2019	2020	2021	2022	2023
Жилийн нийлбэр тунадас, мм						
74	188.3	103.6	104	201.6	82.7	74

Зураг 4-3. Жилийн нийлбэр дундаж хур тунадас



Хур тунадасны сарын хуваарилалтыг авч үзвэл 7-8-р сард хур тунадасны ихэнх унадаг бол 12-1-р сард хур тунадас хамгийн бага унадаг байна.

Зураг 4-4. Сарын нийлбэр дундаж хур тунадас



2.4.3. Салхины горим

Салхины горим нь агаар мандлын орчил урсгал, агаарын даралт, тухайн нутгийн физик газар зүйн нөхцлөөс шалтгаална. Говь хээрийн бүсэд хамаарагдах ба нөмөрлөж хаах уул, нуруу ховор учраас салхитай нутагт хамаарагдана. Гэхдээ хүчтэй шуургалж салхилах нь ховор. Олон жилийн дунджаас үзэхэд салхигүй өдрийн тоо 12 хоног байдаг байна. Салхины зонхилох чиглэл баруун ба баруун хойд талаасаа байдаг. 2-6 м/с хурдтай салхины давтамж 60-аад хувь байна. Хавар цагт салхины хамгийн дээд хурд 30 м/с хүрдэг байна. Энэ үед шороогоор шуурах нь элбэг. 15 м/с-ээс илүү хурдтай хүчтэй салхилдаг хоногийн тоо жилд 20-30 өдөр, явган шуургатай өдөр 10 орчим, хүчтэй цасан шуургатай өдрийн тоо 10 гаруй байдаг.


Хүснэгт 4-4. Салхины үнэмлэхүй их хурд

Сар Үзүүлэлт	I	II	III	IV	V	VI	VII	VIII	IX	X	XI	XII
-----------------	---	----	-----	----	---	----	-----	------	----	---	----	-----

**“ЭМУЛЬСИЙН ТЭСРЭХ БОДИСЫН ҮЙЛДВЭР, АГУУЛАХЫН ЦОГЦОЛБОР” ТӨСЛИЙН 2026 ОНЫ
БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

Салхины дундаж хурд, м/с	24	24	23	23	26	28	22	23	24	24	18	17
--------------------------	----	----	----	----	----	----	----	----	----	----	----	----

Зураг 4-5. Салхины үнэмлэхүй их хурд




Хүснэгт 4-5. Салхины үзүүлэлт

Сар Үзүүлэлт	2017	2018	2019	2020	2021	2022	2023
Их хурд, м/с	26	24	25	22	28	23	27

Дээрх хүснэгтээс үзэхэд тухайн бүс нутагт баруун хойд болон баруун зүгийн салхи зонхилдог болох нь харагдаж байна.

Зураг 4-6. Салхины чиглэл




2.5. Гадаргын болон газар доорх ус

Монгол орны гол, мөрөн, түүний сав газрын хэмжээ, байгалийн нөхцөл, урсац бүрэлдэх зүй тогтол, нөөцийн хуваарьлалт, байгалийн болон засаг захиргааны хил хязгаарыг үндэслэн Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2009 оны 332 дугаар тушаалаар Монгол орны нутаг дэвсгэрийг усны 29 сав газарт хувааж, хил хязгаарыг нь тогтоож өгсөн байдаг бөгөөд үйлдвэр байрлах нутаг дэвсгэр нь Галба Өөш Долоодын говийн сав газарт хамаарна.

**“ЭМУЛЬСИЙН ТЭСРЭХ БОДИСЫН ҮЙЛДВЭР, АГУУЛАХЫН ЦОГЦОЛБОР” ТӨСЛИЙН 2026 ОНЫ
БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

Галба-Өөш, Долоодын говийн сав газар нь Монгол орны зүүн өмнөт хэсэгт 142,287 км² нутаг дэвсгэрийг эзлэн орших бөгөөд Монгол улсын нийт газар нутгийн 9 орчим хувийг хамаардаг. Гадаргын ховор, гүний усаар хэрэглээгээ хангадаг, говь, цөл хээрийн бүс зонхилсон газар нутагтай. Энэ сав газарт Өмнөговь, Дорноговь, Сүхбаатар, Дундговь аймгийн 23 сум хэсэгчлэн болон бүтнээрээ 19 сумын төв, 1 аймгийн төв хамрагдаж байна.

Зураг 6-1. Галба Өөш Долоодын говийн сав газар



2.6. Төслийн талбайн хөрсөн бүрхэвчийн тархалт

Эмүльсийн тэсрэх бодисын үйлдвэр, агуулахын цогцолборын талбай нь Оюутолгой уурхайн зүүн хэсэгт байрлах аараг толгод, хуурай сайр, тэгшивтэр хөндий болон талархаг гадаргад д.т.д 1160-1177 м өндөрт байрлана. Энэхүү талбайд Монгол орны хөрсний шинэчилсэн (Газарзүйн хүрээлэн, 2013 он) ангиллаар Бор хөрсний хэв шинжид багтах чулуурхаг, нимгэн, сайргархаг, элсэнцэр, шавранцар болон ердийн Бор төрлийн хөрснүүд дангаараа болон бүрдэл байдлаар тархсан байна.

Зураг 8-1. Төслийн талбайн хөрсөн бүрхэвч



2.6.1. Хөрсөн бүрхэвчийн эвдрэл, талхагдал

Төслийн талбайн хэмжээнд одоогоор үйлдвэрийн барилга байгууламжид өртсөн 0.75 га, технологийн замд 6.2 га, үйлдвэрийн гаднах ажлын талбайд 4.3 га, тэсрэх материалын агуулахад 2.8 га, бусад эвдэрч талхадсан 7.4 га газар тус тус байна.

2.6.2. Хөрсний хүнд металлын өнөөгийн түвшин

Хортой хүнд металл гэдэгт дараах 11 хүнд металл багтана. Үүнд: Хар тугалга (Pb), кадмий (Cd), хром (Cr), цайр (Zn), никель (Ni), зэс (Cu) орно. Эдгээрээс Cd, Cr, Pb нь онцгой хортой, Cu, Ni, Zn нь хортой био-идэвхт хүнд металлууд гэж үздэг. Онцгой хортой хүнд металлууд нь амьд организмд учруулах хор нөлөөлөл ихтэй, амьд организмд их хэмжээгээр орсон тохиолдолд өвчин үүсгэх улмаар үхүүлэх хүртэл аюултай байдаг. Харин хортой био-идэвхт хүнд металлууд нь хоруу чанарын хувьд онцгой хортой хүнд металлуудаас арай бага, тодорхой хэмжээгээр амьд организмд байх ёстой боловч амьд организмд их хэмжээгээр хуримтлагдвал эндемик буюу орогномол өвчин үүсгэдэг аюултай. Судалгааны үр дүнгээс харахад онцгой хортой хүнд металлуудаас кадми (Cd), био идэвхт хүнд металаас молебден (Mo) маш бага илэрсэн, харин As, Cr, Cu гэсэн металлууд зарим цэгт хүлцэх агууламжаас давсан боловч уул уурхайн бүсэд зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс хэтрээгүй буюу хэвийн түвшинд байна. Харин стандартын хүлцэх агууламжаас хэтрээгүй буюу хэвийн түвшинд байна.


Хүснэгт 8-1. Хөрсөн дэх хүнд металлуудын агууламж

Дээжний нэр	Онцгой хортой хүнд металлууд				Био-идэвхт хүнд металлууд						
	As	Cd	Cr	Pb	Co	Cu	Mo	Ni	Sr	V	Zn
Үйлдвэр талбай-1	19	<1	161	13	21	90.8	2	60	337	140	63
Үйлдвэр талбай-2	29	1	44	10.1	12	409	4	19	358	123	97
Ойн зурвас-1	<3	2	29	8.57	7	33.6	1	14	244	77	65

**“ЭМУЛЬСИЙН ТЭСРЭХ БОДИСЫН ҮЙЛДВЭР, АГУУЛАХЫН ЦОГЦОЛБОР” ТӨСЛИЙН 2026 ОНЫ
БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

Ойн зурвас-2	26	1	33	71.6	8	30.6	1	15	265	86	71
Тэсрэх агуулах	24	2	32	45.1	8	33.2	2	16	257	83	76
Тэсрэх агуулах нойл	9	<1	25	54.3	6	24	1	12	233	72	84
Хүлцэх агууламж (MNS 5850:2019)	20	3	150	100	50	100	5	150	800	150	300
Уул уурхайн бүсэд зөвшөөрөгдөх дээд хэмжээ (MNS 5850:2019)	50	10	400	500	500	500	20	1000	3000	600	600

Зураг 8-2. Хөрсний хүнд металлын түвшин



2.7. Ургамлан нөмрөгийн төлөв байдал

Өмнөговь аймгийн Ханбогд сумын нутагт байрлах үйлдвэрийн талбайн хэсэг нь Монгол орны ургамал газарзүйн тойргоор Дорноговийн цөлөрхөг хээрийн тойрогт хамаарагддаг (Өлзийхутаг Н.).

Зураг 9-1. Монгол орны ургамал газарзүйн мужлал




Тойрогт Говь-Алтайн нурууны зүүн шувтаргын уулсын араар, дорно зүгт ухаа гүвээрхэг, тэгш гадаргатай Дорноговь, Дундговь аймгийн өмнөд, Өмнөговь аймгийн зүүн ба хойд хэсгийг хамаарна. Нийт 480 зүйлтэй ба жинхэнэ говийн цөлөрхөг хээр, цөлийн төлөөлөгчдөөс бүрдсэн ургамлын аймагтай. Зөвхөн тухайн тойрогт тохиолдох 9 зүйл (Urgamal et al. 2016) ургамал бий.

2.8. Амьтны аймаг

Монгол Төвдийн муж, Говийн дэд муж, Алтайн өвөр говийн тойрогт хамаарах учир говь, цөлийн бүсийн бионт зонхилж байна. Алтайн өвөр говийн тойрогт мэрэгчдээс сохор огтоно, шар сүүлт чичүүл, улаан шанаат зурам, сибирийн алаг даага, овын хөх, турайтнаас цагаан зээр, хар сүүлт, хулан, бөхөн, араатнаас үмхий хүрэн, хярс, үнэг, чоно голлоно. Үүнээс гадна зонхилох байр суурийг эзэлдэггүй ч гэсэн тус тойрогт тархсан амьтдаас дурдвал хөх чомч зусаг, урт сүүлт зусаг, улаан шанаат зурам зэрэг болно.

Зураг 10-1. Монгол орны амьтны аймгийн газарзүйн мужлал


**“ЭМУЛЬСЫЙН ТЭСРЭХ БОДИСЫН ҮЙЛДВЭР, АГУУЛАХЫН ЦОГЦОЛБОР” ТӨСЛИЙН 2026 ОНЫ
БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**



2.9. Тусгай хамгаалалттай газар нутаг

Төслийн талбайгаас Говийн бага дархан цаазат газар (ДЦГ)-ын А хэсэг 41 км, Б хэсэг 75 км зайтай оршдог. Иймд улсын тусгай хамгаалалттай газар нутагтай давхцалгүй байна. Мөн Орон нутгийн хамгаалалттай газар нутгийг авч үзэхэд төслийн талбайгаас 60 км зайд орших 50 га талбай бүхий “Мангасын хүрээ” тусгай хамгаалалттай газрыг аймгийн 2021 оны 12-р сарын 28-ны өдөр хамгаалалтад авсан байдаг байна.

Зураг 11-1. Тусгай хамгаалалттай газар нутаг



**ГУРАВ. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН
ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ**

Төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллийг 29 асуулгаар магадлан жагсаан үргэлжлэх хугацаа, нөлөөллийн эрчимшил, болон буцалтгүй болон буцаж нөлөөлөх нөлөөлөл зэргийг тус тус тогтоон дараах хүснэгтэд үзүүллээ.

Хүснэгт 3-1. Болзошгүй нөлөөллийг магадлан жагсаах аргаар үнэлсэн үнэлгээ

Байгаль орчны үзүүлэлтүүд	Шууд	Шууд бус	Өөрөө зохицуулагдах	Богино хугацааны	Урт хугацааны	Буцаж нөлөөлөх	Буцалтгүй нөлөөлөх	Хүчтэй	Дунд зэрэг	Бага зэрэг
1. Байгалийн экосистемийн өөрчлөлт										
Газрын доорх усны нөөцийн өөрчлөлт	x				x		x		x	
Гадаргын усны нөөцийн өөрчлөлт		x			x		x			x
Ургамлын бүтцийн өөрчлөлт	x		x				x		x	
Хөрсний элэгдэл, эвдрэл	x				x		x	x		
Зэрлэг амьтдын орон зай		x			x		x			x
Уур амьсгалын (бичил) өөрчлөлт		x		x			x			x
2. Байгалийн нөөц, ашиглалт										
Газрын доорх нөөц баялаг										
Бэлчээрийн байдал	x			x			x		x	
Эрдэс түүхий эдийн нөөц										
Эрчим хүчний нөөц	x				x		x			x
3. Байгаль орчны чанарын өөрчлөлт										
Газар доорхи усны чанарын өөрчлөлт	x				x		x			x
Гадаргын усны чанарын өөрчлөлт		x								x
Агаарын бохирдол	x		x			x			x	
Хөрсний бохирдол	x				x		x	x		
Хорт бодис усаар дамжин хүн ам, ан амьтанд		x			x	x		x		
Дуу чимээ, шуугианы нөлөө	x			x			x	x		
4. Байгалийн өнгө төрх, түүх соёлын дурсгалт зүйл, археологи, палентологийн олдвор										
Байгалийн үзэсгэлэнт төрх өөрчлөгдөх	x				x		x		x	
Ландшафтын хэлбэр, өнгө өөрчлөгдөх	x				x		x		x	
Тусгай хамгаалалттай газар нутагт нөлөөлөх										
Түүх соёлын дурсгалт зүйлд нөлөөлөх										
Археологи, палеонтологийн олдворт нөлөөлөх										
5. Эдийн засаг, нийгмийн асуудал										
Орон нутгийн орлого нэмэгдэх		x			x	x			x	
Ядуурлыг бууруулахад дэмжлэг болох		x			x	x			x	
Ажлын байр нэмэгдэх	x				x	x			x	
Улирлын чанартай эрэлт хэрэгцээ нэмэгдэх			x							
Хүн амын эрүүл мэндэд нөлөөлөх		x		x		x				x
6. Бусад нөлөөлөл										
Ажлын нөхцөл ажиллагсдын эрүүл мэндэд		x		x			x			x
Ахуйн хаягдал, хогийн цэгийн ариутгал		x		x			x			x
Хүчтэй салхи, түймэр газар хөдлөл, аянга		x		x		x				x
Дүн	12	11	3	7	13	7	15	4	9	10

Шууд нөлөөлөл

Болзошгүй нөлөөллийн 12 (46%) нь шууд нөлөөлөлд хамрагдаж байна. Тэсрэх бодисын үйлдвэр, агуулах төслийн үйл ажиллагаанаас ургамлан нөмрөгийн өөрчлөлт, хөрсний элэгдэл эвдрэл, бэлчээрийн нөөц багасах, газрын доорх усны чанар, ландшафтын хэлбэр зэрэгт сөргөөр нөлөөлж экологийн тэнцвэрт байдлыг алдагдуулж болзошгүй байна.

Шууд бус нөлөөлөл

Уг төслөөс нийт болзошгүй нөлөөллийн 11 (47.8%) нь шууд бус нөлөөлөлд хамрагдаж байна. Уур амьсгалын (бичил) өөрчлөлт, хорт бодис усаар дамжин хүн, орон нутгийн орлого, ахуйн хаягдал, хүчтэй салхи, гал түймэр, хүн амын эрүүл мэнд зэрэгт шууд бусаар нөлөөлөхөөр байна.

Өөрөө зохицуулагдах нөлөөлөл

Тэсрэх бодисын үйлдвэр, агуулах төслөөс нийт болзошгүй нөлөөллийн 3 (12.5%) нь өөрөө зохицуулагдах нөлөөлөлд хамрагдаж байна.

Богино хугацааны нөлөөлөл

Уг төслөөс нийт болзошгүй нөлөөллийн 7 (29.2%) нь богино хугацааны нөлөөлөлд орж байна. Богино хугацааны нөлөөлөлд уур амьсгалын (бичил) өөрчлөлт, Ажлын нөхцөл ажиллагсдын эрүүл мэндэд нөлөөлөх, ахуйн хаягдал, хогийн цэгийн ариутгал муугаас эвгүй үнэр гарах, шавьж үржих, хөрс бохирдох, бэлчээрийн байдал зэрэг богино хугацаанд өөрөө зохицуулагдах нөлөөлөл гэж авч үзлээ.

Урт хугацааны нөлөөлөл

Төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд нөлөөлөх нөлөөллийн 13 (54.1%) нь урт хугацааны нөлөөлөл бөгөөд төслийн байгаль орчинд нөлөөлөх сөрөг нөлөөллийн ихэнхи нь урт хугацааны нөлөөлөлд хамрагдаж байна.

Нөлөөллийн эрчим

Төсөл хэрэгжих орчны байгаль орчинд тухайн төслөөс гарах хүчтэй нөлөөлөлд орчны хөрс, ургамлын элэгдэл, агаар, дуу чимээ, ландшафтын хэлбэр өнгө өөрчлөгдөх зэрэг нөлөөллүүд байна. Дунд зэргийн эрчимтэй нөлөөлөлд газрын гадаргын нөөц баялаг, газрын доорх усны нөөцийн өөрчлөлт, зэрлэг амьтдын орон зайн өөрчлөлт, бэлчээрийн байдал, татварын орлого, бүс нутгийн орлого нэмэгдэх зэрэг нөлөөллүүд багтана. Бага зэргийн эрчимтэй нөлөөлөлд уур амьсгалын өөрчлөлт, үйлчилгээний салбарын үйл ажиллагаа, ахуйн хаягдал, хогийн цэгийн ариутгал муугаас эвгүй үнэр гарах, шавьж үржих, хөрс бохирдох багтаж байна. Нийт 23 нөлөөллөөс 4 хүчтэй, 9 дунд зэргийн, 10 бага зэргийн нөлөөлөл байна.

**“ЭМУЛЬСИЙН ТЭСРЭХ БОДИСЫН ҮЙЛДВЭР, АГУУЛАХЫН ЦОГЦОЛБОР” ТӨСЛИЙН 2026 ОНЫ
БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

3.1. Төслийн байршил, шийдэлтэй холбоотой болзошгүй нөлөөлөлийн үнэлгээ

Хүснэгт 3-2. Төслийн байршил, шийдэлтэй холбоотой болзошгүй нөлөөллийн магадлах жагсаалт

Байгаль орчны асуудал	Нөлөөлөл байхгүй	Нөлөөллийн үр дагавар		
		Бага	Дунд	Их
1. Төслийн байршилтай холбоотой байгаль орчны асуудал				
Голын гольдролыг эвдэж, өөрчлөх	x			
